

НЭГ. ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИАС ХЭРЭГЖҮҮЛДЭГ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дотоод хэргийн их сургууль 2025-2026 оны хичээлийн жилд НЭМЭЛТЭЭР магистрын 4 (Шинжлэн магадлах ухаан; Цагдаа судлал; Кибер гэмт хэрэг судлал; Эдийн засгийн аюулгүй байдал;) хөтөлбөрт элсэлт авч байна.

Элсэлтийн бүртгэлийг 2025 оны 08 дугаар сарын 23-ний өдрөөс 08 дугаар сарын 27-ны хүртлэх өдрүүдэд “elselt.uia.gov.mn” цэсээр бүртгэж, элсэлтийн шалгалтыг 08 дугаар сарын 28-ний өдөр ДХИС дээр зохион байгуулна.

Дотоод хэргийн их сургуулийн магистрын хөтөлбөрт 2 жил буюу 4 улирлын туршид суралцах бөгөөд 2025-2026 оны хичээлийн жилийн I улирлын танхимын сургалт 2025 оны 09 дүгээр сарын 01-нээс 2025 оны 10 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Холбогдох утас: 70155011

“Шинжлэн магадлах ухаан” магистрын хөтөлбөр (БМИУЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн)

“Шинжлэн магадлах ухаан” магистрын сургалтын хөтөлбөр нь байгаль, инженер-техник, нийгэм, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл, шинжлэн магадлах чиглэлээр бакалаврын зэрэг эзэмшсэн суралцагчдад магадлах шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэл бүхий шинжээчийн дүгнэлт гаргах, шинжлэн магадлахуйн тулгамдаж байгаа асуудлуудыг нээн илрүүлэх, шийдвэрлэх онол, арга зүй, технологийг тодорхойлох мэдлэг, ур чадвартай, шинжээчийн ёс зүйг баримтлан шударга, шинжлэх ухаанчаар хандах хандлагатай магадлах шинжээч-судлаачийг (Forensic Scientist) бэлтгэхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөр юм.

Хөтөлбөрийн зорилт, суралцахуйн үр дүн:

Шинжлэн магадлахуйн онолын мэдлэг, судалгааны чадварт тулгуурлан асуудалд системийн сэтгэлгээний үүднээс дүн шинжилгээ хийх, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй шинжээч бэлтгэх зорилготой.

- Суралцагчдад хууль зүй, шинжлэн магадлахуй, криминалистикийн онол, судалгааны арга зүйн академик мэдлэгт тулгуурлан судалгааны ажлын дизайн боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах мэдлэгийг эзэмшүүлэх.
- Суралцагчдад хэргийн газарт мөртэй ажиллах, шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийж дүгнэлт гаргах цогц чадамжийг эзэмшүүлэх.
- Шинжилгээг хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хараат бус байх, шинжээчийн ёс зүйг баримтлан, шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нууцыг хадгалан, аюулгүй байдлыг ханган хийх хандлагыг төлөвшүүлэх.
- Асуудалд системийн шинжилгээний болон шинжлэн магадлахуйн судалгааны арга зүйн үүднээс дүн шинжилгээ хийх арга барилд суралцах, асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийн хувилбар боловсруулах, судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан туршилт, судалгаа хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга зүйг эзэмшүүлж, судлаачийн ёс зүйг баримтлах хандлагыг төлөвшүүлнэ.
- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй, мэргэжлийн үйл ажиллагаагаа

хэрэгжүүлэхэд ямагт бэлэн, тангарагтаа үнэнч, асуудал шийдвэрлэх, хариуцлагатай, судлаачийн өндөр ёс зүйтэй байх сэтгэлгээг төлөвшүүлэх.

“Цагдаа судлал” магистрын хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго:

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, туршилт, шинжилгээ хийх ур чадвар, арга барил эзэмшиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, мэргэжлийн болон судлаачийн ёс зүйг баримтлан ажиллах хандлага төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн:

Төгсөгчид цагдаагийн эрх зүй, цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны онол, практик, эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг, арга зүйн асуудалд дүн шинжилгээ хийх, дүгнэлт, санал дэвшүүлэх ур чадвар эзэмшүүлэх, судлаачийн ёс зүйтэй байх хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

“Кибер гэмт хэрэг судлал” магистрын сургалтын хөтөлбөр *(Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтарсан хөтөлбөр)*

Хөтөлбөрийн зорилго:

Хууль сахиулах салбарын болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн мэргэжилтэн, иргэнийг мэдээллийн аюулгүй байдал судлалыг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын асуудалд шинжлэх ухаанч байр сууринаас хандаж, нотолгоонд суурилан шийдвэрлэх ур чадварыг эзэмшсэн, цахим орчинд үйлдэгдэх халдлагаас улс, нийгмийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон техникийн мэдлэгтэй, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай, оперативын түвшинд мэргэшсэн боловсон хүчин болгон бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт, суралцахуйн үр дүн:

- Кибер гэмт хэрэг судлалын онол, хандлага, аюул занал, халдлага, түүний хор уршгийн талаар болон судалгааны арга зүйн мэдлэг эзэмших;
- Кибер гэмт хэрэг судлалын онолын мэдлэгт суурилсан суурь болон хавсарга судалгаа (статистик дүн шинжилгээ, мэдээллийн технологи ашиглах, харьцуулан судлах) хийж үр дүн гаргах (магистрын ажил бичих) ур чадварыг хөгжүүлэх;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого, салбар хооронд, байгууллагын тулгамдсан асуудлуудыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх ажилтны мэргэжлийн болон хувийн шинж чанаруудыг хөгжүүлснээр хууль сахиулах байгууллагууд болон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шинэ арга барилыг бий болгох, өөрийн мэдлэгийг бусдад түгээх чадвар бүхий аюулгүй байдлын ажилтныг бэлтгэх;

“Эдийн засгийн аюулгүй байдал судлал” магистрын хөтөлбөр *(Хөдөө аж ахуйн их сургуультай хамтарсан хөтөлбөр)*

Хөтөлбөрийн зорилго:

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй эерэг болон сөрөг хүчин зүйлийг судалгааны үндэслэлтэй тодорхойлох, учирч болох аюул заналаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх арга зүйг боловсронгуй болгоход чиглэсэн мэдлэг, ур чадвар бүхий судлаач, мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт, суралцахуйн үр дүн:

- Эдийн засгийн аюулгүй байдлын онол, хандлага, суурь судалгааны арга зүйн талаар мэдлэг эзэмших;
- Эдийн засгийн аюулгүй байдлын онолын мэдлэгт суурилсан суурь болон хавсарга судалгаа (статистик дүн шинжилгээ, мэдээллийн технологи ашиглах, харьцуулан судлах) хийж үр дүн гаргах (магистрын ажил бичих) ур чадварыг хөгжүүлэх;
- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, салбар хооронд, байгууллагын тулгамдсан асуудлуудыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;
- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ажилтны мэргэжлийн болон хувийн шинж чанаруудыг хөгжүүлснээр хууль сахиулах байгууллагууд болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шинэ арга барил төлөвших;

Дотоод хэргийн их сургуулийн магистрын хөтөлбөрт элсэгчдэд тавих шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалт

1. Тавигдах шаардлага:

- Элсэхийг хүсэгч нь тухайн мэргэжлээр бакалаврын боловсрол түүнтэй дүйцэхүйц боловсрол эзэмшсэн байх, бакалаврын дипломын голч дүн 2.8 (80)-аас дээш байх, төрийн албанд болон мэргэжлээрээ 3-аас доошгүй ажилласан туршлагатай байх;
- Судалгааны ажлын агуулга, чиглэл, зорилгын талаар бичсэн 6-8 хуудас танилцуулга бүхий эсээг Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний ажил, сургалтын баримт бичгийн стандартын дагуу бичсэн байх;
- Гадаад хэлний дунд болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй байх.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

2.1. Магистр, докторын хөтөлбөрт элсэгчдэд тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан иргэд шалгалт өгнө.

ГУРАВ. ЭЛСЭЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Элсэлт зохион байгуулах чиглэл	Он. сар. өдөр. цаг	Хариуцах газар, албан тушаалтан
Магистр, докторын элсэлтийн бүртгэл			
1	Магистр, докторын элсэлтийн бүртгэл	2025.08.23-08.27-ны хүртлэх өдрүүдэд	Цахимаар бүртгүүлнэ elselt.uia.gov.mn
Магистрын хөтөлбөрийн элсэлтийн шалгалт			

2	Мэргэжлийн мэдлэг	2025.08.28 ны 10 цагаас	Комиссын бүрэлдэхүүн
3	Гадаад хэл		Комиссын бүрэлдэхүүн
4	Ярилцлага		Комиссын бүрэлдэхүүн

ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, АГУУЛГА

№	Шалгалтын төрөл	Хөтөлбөрийн нэр	Хэлбэр	Агуулга
1	Гадаад хэл /30 оноо/	Шинжлэн магадлах ухаан; Цагдаа судлал; Кибер гэмт хэрэг судлал; Эдийн засгийн аюулгүй байдал;	20 сорил, орчуулах текст	Анхан дундаас дээш түвшний агуулгатай байна. /Орос, Англи хэлний аль нэг нь байж болно/
2	Ярилцлага /20 оноо/	Шинжлэн магадлах ухаан; Цагдаа судлал; Кибер гэмт хэрэг судлал; Эдийн засгийн аюулгүй байдал;	Ярилцлага	Урьдчилан ирүүлсэн судалгааны ажлын талаарх танилцуулгын хүрээнд ярилцана.
3	Мэргэжлийн мэдлэг /50 оноо/	Шинжлэн магадлах ухаан	50 сорил	Шинжлэн магадлахуйн эрх зүй-10 Эрүүгийн процессын эрх зүй-5 Байгалийн ухаан-5 Хэргийн газрын үзлэг-10 Шинжилгээний арга зүй-20
		Цагдаа судлал	50 сорил	Үндсэн хуулийн эрх зүй-10 Эрүүгийн эрх зүй-10 Цагдаагийн эрх зүй-30
		Эдийн засгийн аюулгүй байдал	50 сорил	Эдийн засаг-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20
		Кибер гэмт хэрэг судлал	50 сорил	Техникийн ухаан-20 Аюулгүй байдал-10 Эрх зүй-20

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ